



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 1188

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.5, 5.8 дахь заалт, МУИС-ийн захиргааны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дэмжигдсэн "Монгол улсын их сургуулийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, Хүрээлэн төв байгуулах төслийн саналын агуулгыг 2 дугаар хавсралтаар, Хүрээлэн төвийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар баталж, 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Батлагдсан журмыг сургуулийн цахим хуудсанд байршуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, дотоод хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал (Ч.Ундрам), Эрдэм шинжилгээ, инноваци, гадаад харилцаа хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг) нарт үүрэг болгосугай.

ДЭД ЗАХИРАЛ



Б.ОЧИРХУЯГ

My document. Tushaal. 2017.June

20171447



Захирлын 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 188 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1.1 дүгээр зүйл Журмын зорилго

1. Хүрээлэн, төвийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, МУИС-ийн Дүрэм болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийг баримтлан Монгол Улсын Их сургуульд судалгааны хүрээлэн, төв (цаашид “хүрээлэн, төв” гэх) байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааг үнэлэх, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 дугаар зүйл Журмын нэр томъёоны тодорхойлолт

1.2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1.2.1.1 “Хүрээлэн” гэж салбар дундын цогц асуудал шийдвэрлэх зорилгоор судалгааны үйл ажиллагаа явуулдаг, хоёр ба түүнээс дээш бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш, судлаачдаас бүрдсэн бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга нь наймаас доошгүй, үүсгэн байгуулах саналыг холбогдох бүрэлдэхүүн сургуулиас дэвшүүлдэг МУИС-ийн нэгжийг;

1.2.1.2 “Төв” гэж тодорхой салбарын судалгаа болон үйлчилгээ эрхлэн явуулах зорилго бүхий нэг эсхүл хэд хэдэн тэнхим болон бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш, судлаачдын бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга гурваас доошгүй, үүсгэн байгуулах саналыг тэнхмээс дэвшүүлдэг бүрэлдэхүүн сургуулийн нэгжийг;

1.2.1.3 “Үүсгэн байгуулагч” гэж Монгол Улсын Засгийн газар, төрийн болон хувийн хэвшил, олон улсын байгууллага, гадаадын их дээд сургууль, МУИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулийн захиргаа, тэнхим;

1.2.1.4 "Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төв" гэж Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор байгуулагдан шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл, цөм технологийн чиглэлээр судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа явуулдаг хүрээлэн, төвийг;



1.2.1.5 "МУИС-ийн хүрээлэн, төв" гэж МУИС-ийн захирлын тушаалаар байгуулагдан шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл, цөм технологийн чиглэлээр судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа явуулдаг хүрээлэн, төвийг;

1.3 дугаар зүйл Нийтлэг зарчим

1.3.1 Хууль дээдлэх

1.3.2 Судалгаанд үндэслэгдсэн байх

1.3.3 Судлаачдын оролцоог хангах

1.3.4 Ил тод нээлттэй

1.3.5 Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

1.3.6 Судалгааны ёс зүйг дээдлэх

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮРЭЭЛЭН, ТӨВ БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

2.1 дүгээр зүйл Хүрээлэн, төвийг байгуулах

2.1.1 Үүсгэн байгуулагч нь хүрээлэн, төв байгуулах төслийн саналыг (Хавсралт 2)-ын дагуу боловсруулна.

2.1.2 МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлын саналыг үндэслэн хүрээлэнг, бүрэлдэхүүн сургуулийн Захиргааны зөвлөлийн саналыг үндэслэн төвийг МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулна.

2.1.3 МУИС-д хүрээлэнг байгуулах хүсэлт гаргах үүсгэн байгуулагч нь бүрэлдэхүүн сургууль, төв байгуулах хүсэлт гаргах үүсгэн байгуулагч нь тэнхим байна.

2.1.4 Хүрээлэн, төв байгуулахад дараахь үндсэн шаардлагыг баримтална.
Үүнд:

2.1.4.1 Шинээр байгуулагдах хүрээлэн, төвийн үйл ажиллагаа нь МУИС-ийн бусад нэгжийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй давхцахгүй байх

2.1.4.2 Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал;

2.1.4.3 Санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийн тооцоо;

2.1.4.4 Үйл ажиллагааг батлах бүтээл, туурвил, оюуны өмч;

2.1.4.5 Судалгааны шууд бус зардлын шимтгэл төлөх төлөвлөгөө;

2.2 дугаар зүйл Хүрээлэн, төвийн бүтэц, зохион байгуулалт

2.2.1 Хүрээлэн, төв нь МУИС-ийн нэгж байна.

2.2.2 Хүрээлэн, төв нь захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга (ЭНБД)-тай байна.

2.2.3 Хүрээлэн, төвийн захирал, ЭНБД даргын ажлыг МУИС-ийн профессор, дэд профессорын албан тушаал дээр ажиллаж байгаа үндсэн багш тухайн хүрээлэн, төвөөс 40 хүртэлх хувийн нэмэгдэл цалинтай хавсран гүйцэтгэж болно.

2.2.4 МУИС-ийн хүрээлэн, төвийн захирлыг МУИС-ийн захирлын тушаалаар гурван жилийн хугацаатай томилно.

2.2.5 Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төвийн захирлыг МУИС-ийн Дүрмийн 3.8-ын дагуу томилно.

2.2.6 Эрдэм шинжилгээ, инновац, гадаад харилцаа (ЭШИГХ) хариуцсан дэд захирал судалгааны хүрээлэн, төвийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

2.2.7 Хүрээлэн, төвийн захирал нь ЭШИГХ хариуцсан дэд захиралтай үр дүнгийн гэрээ байгуулна.

2.2.8 Хүрээлэн, төвийн ЭНБД-ыг тус нэгжийн эрдэм шинжилгээний ажилтны гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлын олонхийн саналыг үндэслэн МУИС-ийн Захирлын тушаалаар томилно.

2.3 дугаар зүйл Хүрээлэн, төвийн дотоод журам


2.3.1 Хүрээлэн, төв нь МУИС-ийн дүрэм болон энэхүү нийтлэг журамд нийцүүлэн баталсан өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод журамтай байна.

2.3.2 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, “МУИС-ийн Дүрэм”, “МУИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө”, МУИС-д судалгааны үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох журмуудтай нийцүүлэн баталсан хүрээлэн, төвийн дүрэм, дотоод журам нь түүний үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг бөгөөд дор дурьдсан мэдээлэл багтсан байна. Үүнд хүрээлэн, төвийн:


2.3.3 Оноосон нэр, оршин байгаа газрын хаяг

2.3.4 Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.3.5 Хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт



- 2.3.6 Тодорхой хугацаагаар байгуулж байгаа бол тус хугацааг тусгах
- 2.3.7 Хөрөнгө, үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр
- 2.3.8 Холбогдох шийдвэр, үйл ажиллагааны талаарх тайлан бусад мэдээллийг МУИС-ийн удирдлага бусад холбогдох этгээдэд хүргэх, мэдээлэх үйл явц.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ҮҮРЭГ

3.1. Хүрээлэн төвийн үйл ажиллагаа

3.1.1 Хүрээлэн, төв нь суурь болон хэрэглээний шинжлэх ухааны судалгаа хийх, дотоод гадаадын байгууллагатай хамтран эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, тухайн салбарын мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, шинэ техник, технологи боловсруулж үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх, өөрийн бий болгосон оюуны өмчийг бизнесийн эргэлтэнд оруулах замаар инноваци, технологи дамжуулалтыг хөгжүүлэх зэрэг чиглэлээр бие даасан үйл ажиллагаа явуулна.

3.1.2 Хүрээлэн, төв нь үйл ажиллагаандаа судалгааны эрх чөлөө, бүтээлч байдлыг удирдлага болгон шинжлэх ухааны үнэнийг эрэлхийлэн, багаар хамтран ажиллахыг чухалчлах ба эрдэм мэдлэгийн үнэ цэнийг эрхэмлэн, шинжлэх ухааны болон судлаачийн ёс зүйг чанд дагаж мөрдөнө.

3.1.3 Хүрээлэн, төв нь "МУИС-ийн барааны тэмдэг ашиглах тухай журам"-ын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, үйл ажиллагааг илэрхийлсэн бэлэгдэл, логотой байж болно.

3.2 Судалгааны хүрээлэн, төвийн захирлын эрх, үүрэг

3.2.1 Хүрээлэн, төвийн захирал үндсэн, гэрээт ажилтныг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, ажилтныг МУИС-ийн захирал баталгаажуулна.

3.2.2 Хүрээлэн, төвийн судалгааны ажлын төлөвлөгөөг боловсруулна.

3.2.3 Төсвийг (санхүүгийн жилээр) төлөвлөж, харьяалагдах нэгжийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.(Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төвүүдэд үл хамаарна)

3.2.4 Судалгааны шууд бус зардлын шимтгэлийн үр дүнгийн гэрээнд заасан


хувийг захиран зарцуулна.

3.2.5 Судалгааны ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.2.6 Гадаад, дотоод хамтын ажиллагааг тогтоож, өргөжүүлнэ.

3.2.7 Хүрээлэн, төвийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шаардлагатай тохиолдолд бусад бүрэлдэхүүн сургуулийн багш, докторант, магистрант, эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдыг оролцох боломжоор хангаж ажиллана.

3.2.8 Хүрээлэн, төвийн захирал судалгааны үйл ажиллагааны тайланг МУИС-ийн Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн систем (ЭШММС)-д бүртгүүлнэ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН САНХҮҮЖИЛТ, ҮНЭЛГЭЭ

4.1 Хүрээлэн, төвийн санхүүжилт

4.1.1 Хүрээлэн, төвийн өмч хөрөнгө нь МУИС-ийн өмчлөлд байна.

4.1.2 Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төв нь тусдаа бие даасан данстай байна. МУИС-ийн хүрээлэн, төвийн санхүүжилт нь МУИС-ийн дансаар дамжина.

4.1.3 Хүрээлэн, төвийн хөрөнгө, үйл ажиллагааны санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

4.1.3.1 Монгол Улсын Засгийн газрын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, суурь зардал;

4.1.3.2 МУИС-ийн төсвийн санхүүжилт (байгууллагын бодлогоор дэмжих чиглэлийн хүрээлэн, төвийн хувьд);

4.1.3.3 Олон улсын болон үндэсний хэмжээний судалгааны ажлын санхүүжилт;

4.1.3.4 Хүрээлэн, төвийн үйл ажиллагаанаас олох орлого;

4.1.3.5 Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төсөл, захиалгат болон гэрээт ажил;

4.1.3.6 Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн шууд бус зардлын шимтгэл;

4.1.3.7 Хандив, тусламж;

4.2 Хүрээлэн, төвийн үйл ажиллагааны үнэлгээ

4.2.1 Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс нь хүрээлэн, төвийн үйл

ажиллагааг үр дүнгийн гэрээний гүйцэтгэлээр гурван жил тутамд энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан иж бүрэн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

4.2.2 Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааг МУИС-ийн Дүрмийн 4.2.10.8 -ын дагуу үнэлнэ.

4.2.3 ЭШИГХ хариуцсан дэд захирал шаардлагатай тохиолдолд хүрээлэн, төвийн үйл ажиллагааны үнэлгээг гүйцэтгэх мэргэжлийн шинжээчийн багийг таваас доошгүй профессор, судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр томилж, удирдамжаар ханган дүгнэлт гаргуулна.

4.2.4 МУИС-ийн хүрээлэн, төвийн үнэлгээ нь тэдгээрийг урамшуулах, дэмжлэг үзүүлэх, өөрчлөн байгуулах эсхүл татан буулгах, захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээг сунгах, цуцлах үндэслэл болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙГ ТАТАН БУУЛГАХ

5.1 Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хүрээлэн, төвийн ажлын үнэлгээ нь хангалтгүй тохиолдолд бүтцийг өөрчлөх, татан буулгах саналыг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

5.2 МУИС-ийн хүрээлэн, төвийг МУИС-ийн захирлын тушаалаар дараахь тохиолдолд татан буулгана.

5.2.1 Төлөвлөгөөт үйл ажиллагаагаа хэрэгжүүлж дууссан;

5.2.2 Зорилгод нийцсэн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон;

5.2.3 Үр дүнгийн гэрээнд заасан гүйцэтгэл хангалттай бус эсхүл үйл ажиллагаа явуулаагүй;

5.2.4 Санхүүжилтийн эх үүсвэргүй;

5.2.5 Үйл ажиллагааг зогсоох талаар шүүхийн шийдвэр гарсан;


5.2.6 Хамт олны гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас олонхийн саналаар татан буулгах тухай шийдвэр гаргасан

5.2.7 Үндсэн зорилгын чиглэлийн дагуу биш үйл ажиллагаа явуулсан (улс төрийн гэх зэрэг)

5.2.8 Хүний нөөц орон тооны доод хязгаарт хүрэхгүй болсон;

5.3 Судалгааны хүрээлэн, төв татан буугдахад мөнгөн хөрөнгө тоног төхөөрөмж нь бүрэлдэхүүн сургуулийн эзэмшилд шилжинэ.

5.4 Судалгааны хүрээлэн, төв татан буугдахад хүний нөөцийн асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



ЗУРГАДУГААР БҮЛЭГ

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1 Журамтай холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монголын олон улсын ба үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ.



Захирлын 2017 оны 06 дугаар сарын 23-ны
өдрийн 1/188 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Хүрээлэн, төв байгуулах төслийн саналын агуулга

1. Хүрээлэн төвийн нэр
2. Хүрээлэн, төвийн захиралд нэр дэвшигчийн намтар, ажлын туршлага, бүтээлийн жагсаалт
3. Хүний нөөц, гишүүдийн намтар, бүтээлийн жагсаалт
4. Хүрээлэн, төвийг байгуулах үндэслэл
5. Үйл ажиллагааны зорилго, зорилтууд
6. Зохион байгуулалт
7. Оршин байх хаяг
8. Судалгааны дэд бүтэц
9. Үйл ажиллагааны төлөвлөгөө
10. Төсөв
11. Хүрээлэн, төвийн хүлээгдэх судалгааны үр дүн
12. Эрсдлийн менежментийн төлөвлөгөө



Захирлын 2017 оны 06 дугаар сарын 22-ны
өдрийн 1188 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

Хүрээлэн, төвийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

| Үзүүлэлт | Үзүүлэлтийн агуулга | Оноо |
|--|---|------------------------|
| Судалгааны гүйцэтгэл | 1.Байгалийн ухаан, инженерчлэлийн салбар Web of Science-ын JCR, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбар Web of Science-ын JCR болон Scopus-ын бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл 2.Олон улсад хэвлүүлсэн монографи 3.Оюуны өмч -Идэвхитэй патентын тоо /гадаад, дотоод/ -Идэвхгүй патентын тоо -Патентын мэдүүлэг /гадаад, дотоод/ -Ашигтай загвар -Бүтээгдэхүүний загвар 4.МУИС-ийн дансаар орж ирсэн төслийн санхүүжилтийн хэмжээ/гадаад, дотоод/ 5.Гэрээт ажил 6.Захиалгат ажил | 40 10 20 |
| Мэргэжилтэн бэлдэх багийн бүтэц, зохион байгуулалт, судлаач бэлтгэн мэргэшүүлэх, судалгааны туслахын оролцоо | 7.магистрант, докторант, докторын дараах судлаачийн оролцоо 8.Гэрээгээр ажиллаж буй судалгааны туслахын тоо 9.Мэргэжил дээшлүүлэлт | 20 |
| Нээлттэй байдал ба гадаад харилцаа, манлайлах чадвар | 10.Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд бодит хийгдсэн ажил 11.Хамтарсан хөтөлбөр 12.Зөвлөх үйлчилгээ 13.Хурал, семинар 14.Мэргэжлийн үйлчилгээ олон нийтэд үйлчилсэн байдал -Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийсэн байдал -Зочин судлаач | 10 |